



## НИЙСЛЭЛИЙН СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨНИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 4/03

Улаанбаатар хот

Г Албан хаагчийн ёс зүйн дурмийг  
шинэчлэн батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5., Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийн 2.2 дахь заалтуудыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Соёлын төв өргөөний ажилтны ёс зүйн дүрэм"-ийг шинэчлэн, хавсралтаар баталсугай.
2. Энэ дүрмийг 2018 оны 02 дугаар сарын 1-нээс эхлэн мөрдөж, нийт ажиллагсадад танилцуулах, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Захиргааны зөвлөлийн гишүүд, албадын дарга, Хүний нөөцийн ажилтан нарт даалгасугай.



Нийслэлийн Соёлын Төв өргөөний  
захирлын 2018...оны ... дугаар  
сарын ..... өдрийн  
2018 дугаар тушаалын хавсралт

## СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨНИЙ АЖИЛТНЫ ЕС ЗҮЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Соёлын төв өргөөний албан хаагчдын албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээг тогтоон хэвшүүлэхэд энэ дүрмийн зорилго оршино.

1.2. Соёлын төв өргөөний алба, нэгжийн ажилтан бүр энэхүү дүрмийг мөрдөж, хяналт, хариуцлагын тогтолцоог бурдуулэн ажиллана.

### Хоёр. Ёс зүйн зарчим

2.1. Соёлын төв өргөөний албан хаагчид үйл ажиллагаандаа дор дурдсан зарчмыг баримтална:

- 2.1.1. шударга ёсны;
- 2.1.2. хууль дээдлэх;
- 2.1.3. тэгш байдал;
- 2.1.4. хариуцлага хүлээх;
- 2.1.5. олон нийтэд үйлчлэх.

### Гурав. Ёс зүйн эрхэмлэн дээдлэх зүйлс

3.1. Соёлын төв өргөөний албан хаагчид нь энэ дүрмийн 2.1-д заасан зарчмын хүрээнд нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны бодлого, хөтөлбөр, байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлж, үзэгч, олон нийтэд үйлчилгээ үзүүлэхдээ дор дурдсан зүйлсийг эрхэмлэн дээдэлнэ:

3.1.1. Шударга ёсны зарчмын хүрээнд: Хүлээсэн үүрэгтээ үнэнч байж, нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх, хууль бус, шударга бус явдалтай эвлэршгүй байж, бусдыг манлайлах;

3.1.2. Хууль дээдлэх зарчмын хүрээнд: Үзэгч, олон нийтэд үйлчлэх бүхий л үйл ажиллагаанд хууль тогтоомжийг мөрдөж ажиллах;

3.1.3. Тэгш байдлын зарчмын хүрээнд: Бусад төрийн албан хаагч болон үйлчлүүлэгч, иргэн бүртэй адил тэгш, алагчлалгүй харьцаан байгууллагын хөгжилд өөрийн хувь нэмрийг оруулах;

3.1.4. Хариуцлага хүлээх зарчмын хүрээнд: Албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай өөрийн мэдлэг чадварыг байнга дээшлүүлж, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх;

3.1.5. Олон нийтэд үйлчлэх зарчмын хүрээнд: Үзвэр үйлчилгээг үзэгч, олон нийтэд чанартай, хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэж, тэдний итгэлийг хүлээж ажиллах.

### Дөрөв. Ёс зүйн хэм хэмжээ

4.1. Соёлын төв өргөөний ажилтан нь энэхүү дүрмийн 3.1.1-д заасан эрхэмлэн дээдлэх зүйлсийн хүрээнд дор дурдсан ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө:

4.1.1. Жөдөлмөрийн хууль, байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу ажлын цагийг бүрэн, үр бүтээлтэй ашиглах;

4.1.2. Өөрийн байгууллага, олон нийтийн эрх ашгийг хувийн ашиг сонирхлоос ямагт дээгүүр тавьж, өөрт олгогдсон эрхээ хэрэгжүүлэхдээ ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй аливаа нөхцөл байдлаас татгалзах;

4.1.3. Албан үүргээ гүйцэтгэсэн болон гүйцэтгээгүйн улмаас ашиг сонирхол нь хөндөгдөх дотоод, гадаадын аливаа иргэн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, тэдэнтэй үгсэн тохирох, амлалт өгөх, тэднээс шан харамж, хөнгөлөлттэй үйлчилгээ, зээл авах, хууль бус бусад хангамж эдлэхгүй байх.

**4.2. Соёлын төв өргөөний ажилтан нь энэхүү дүрмийн 3.1.2-т заасан эрхэмлэн дээдлэх зүйлсийн хүрээнд дор дурдсан ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрднө:**

4.2.1. Хууль тогтоомж, эрх зүйн акт, байгууллагын хэмжээнд дагаж мөрдж байгаа соёл, дэг журам, дүрэм, зааврыг чанд баримтлах;

4.2.2. Харьяа дээд шатны албан тушаалтныг асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргахад нь хуульд нийцсэн, бодит баримт нотолгоонд тулгуурласан, үндэслэл бүхий үнэн зөв мэдээлэл, зөвлөгөөгөөр хангах;

4.2.3. Албан үүргээ гүйцэтгэж байхдаа байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг задруулахгүй байж, хувийн болон бусдын ашиг сонирхлын төлөө ашиглах, албан ёсны аливаа мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр тараахгүй байх;

4.2.4. Байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, албаны мэдээллийг албаны бус зорилгоор ашиглахгүй байх.

**4.3. Соёлын төв өргөөний ажилтан нь энэхүү дүрмийн 3.1.3-т заасан эрхэмлэн дээдлэх зүйлсийн хүрээнд дор дурдсан ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрднө:**

4.3.1. Албан тушаалын эрхээ хэрэгжүүлэхдээ иргэд, үйлчлүүлэгч, хамтран ажиллагсадтайгаа эелдэг, адил тэгш, хүлээцтэй, хүндэтгэлтэй харилцаж, үзвэр, соёлын үйлчилгээг чирэгдэл, ялгаварлалгүйгээр хөнгөн шуурхай хүргэх;

4.3.2. Үйлчилгээ үзүүлэхдээ хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдал, бэлгийн хандлагаар нь ялгаварлан гадуурхахгүй байх;

4.3.3. Танил тал, наиз нөхөд, гэр бүл, төрөл садангийн хүмүүс ажиллаж байгаа байгууллага, тэдний ашиг сонирхолтой холбоотой асуудлаар албаны нэр барих зэргээр албан тушаал, эрх мэдлээ хууль бусаар ашиглахыг цээрлэх;

4.3.4. Албан тушаалын эрхээ урвуулан ашиглах, бусдыг дарамтлах, хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгахыг хориглох;

4.3.5. Бусад ажилтны үйл ажиллагаанд саад болох, хууль бус үйлдэл хийхийг шаардах, үүрэг даалгавар өгөхийг хориглох.

**4.4. Соёлын төв өргөөний ажилтан нь энэхүү дүрмийн 3.1.4-т заасан эрхэмлэн дээдлэх зүйлсийн хүрээнд дор дурдсан ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрднө:**

4.4.1. Албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай өөрийн мэдлэг чадварыг байнга дээшлүүлж, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хулээх;

4.4.2. Ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг биечлэн хангах;

4.4.3. Удирдлагын санаа бодолд нийцэх эсэхийг үл харгалзан тэдний гаргах шийдвэрээс үүдэн гарч болзошгүй үр дагавар, сөрөг талыг урьдчилан анхааруулж байх;

4.4.4. Захирах, захирагдах ёсны зарчмыг баримталж, тодорхой асуудлаар өөр саналтай байсан ч удирдлагаас гаргасан хуульд нийцсэн шийдвэр, өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлэх;

4.4.5. Албан үүргээ гүйцэтгэж байхдаа буюу ажлын байрандаа согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх, этгээд байдлаар хувцаслах, бүдүүлэг зан авир гаргахыг цээрлэх;

4.4.6. Албан ажилд шаардлагатай мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд саад учруулахыг цээрлэх;

4.4.7. Байгууллагынхаа зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх талаар төрийн байгууллагаас явуулж байгаа бодлого, үйл ажиллагааг эсэргүүцсэн мэдээ, мэдээлэл тараахгүй байх.

#### **4.5. Соёлын төв өргөөний ажилтан нь энэхүү дүрмийн 3.1.5-д заасан эрхэмлэн дээдлэх зүйлсийн хүрээнд дор дурдсан ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрднө:**

4.5.1. Албан үүргээ хэрэгжүүлэхдээ хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

4.5.2. Төрийн албаны соёл, дэг журмыг баримтлан иргэдтэй соёлтой харилцах;

4.5.3. Үзэгч, олон нийтэд үзүүлэх үйлчилгээг зохих дурэм, журмын дагуу хургэх.

#### **Тав. Албан хаагчдад хориглох зүйл.**

5.1.1. Албан хаагчдыг дүрмээр тогтоосон ёс зүйн хэм хэмжээ<sup>1</sup>-г зөрчихийг хориглоно.

#### **Зургаа. Ёс зүйн хэм хэмжээг хянан шийдвэрлэх.**

Ёс зүйн зөрчил гэж холбогдох хууль болон энэ дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн санаатай буюу санамсаргүй үйлдлийг хэлнэ.

##### **6.1. Ёс зүйн зөрчлийг дараах үндэслэлээр шалгана.**

6.1.1. Байгууллага, иргэдээс гаргасан өргөдөл, гомдл, мэдээлэл,

6.1.2. Дотоод хяналт шалгалтаар илэрсэн,

6.1.3. Шаардлагатай гэж үзвэл удирдлага, Захиргааны зөвлөлийн гишүүдийн санаачлагаар,

6.1.4. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр мэдээлэгдсэн,

6.1.5. Байгууллагын ажилтнуудаас гомдол мэдээлэл ирсэн,

6.1.6. Эрх бүхий байгууллагаас үүрэг өгөгдсөн,

6.2. Ажилтан, албан хаагдын ёс зүйн байдалд албаны дарга, хүний нөөцийн ажилтан, нар хяналт тавьж, зөрчил гаргасан тохиолдолд сахилгын шийтгэл оногдуулах, саналаа Захиргааны зөвлөлийн хуралд оруулж, хэлэцүүлнэ.

#### **Долоо. Хариуцлага**

Ёс зүйн дүрмээр тогтоосон хориглосон болон, Төрийн албан тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5<sup>2</sup> дугаар, Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн

<sup>1</sup> Энэхүү дүрмээр тогтоосон ёс зүйн хэм хэмжээ;

<sup>2</sup> Төрийн албаны болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн байгууллага, албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдлэх;

40.1.4<sup>3</sup> дүгээр заалтуудыг зөрчсөн тохиолдолд байгууллагын үйл ажиллагааны дүрэм, хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээний холбогдох заалтын дагуу Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэцүүлэн, эрх бүхий албан тушаалтан сахилгын шийтгэл ногдуулна.

---

<sup>3</sup> Ажилтан хөдөлмөрийн сахилгын зөрчлийг давтан гаргасан, эсхүл хөдөлмөрийн харилцааг шууд зогсоохоор хөдөлмөрийн гэрээнд тухайллан заасан ноцтой зөрчил гаргасан;